



# МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ

## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮНГЭЭС



Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцооны үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд төлөвлөлтийн хангалтгүй байдал нөлөөлж байна.

Аудитын дүгнэлтээс, 2020 он

# ГАРЧИГ

## “МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

1. Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөлт
2. Аудитын ерөнхий дүн
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгүүд
4. Захиалагчийн саналд үндэслэсэн байдал
5. Улсын төсвийн хөрөнгө оруулалттай шинээр эхлэх болон шилжих төсөл, арга хэмжээний төлөвлөлт
6. Улсын төсвийн хөрөнгө оруулалттай төсөл, арга хэмжээ, шилжсэн төсөл, арга хэмжээ
7. Улсын төсвийн хөрөнгө оруулалттай төслүүд төсөвлөлтийн шаардлага хангасан эсэх талаарх дүгнэлт
8. Худалдан авах ажиллагаа
9. ТАХ-ний эрхийг шилжүүлсэн байдал, ХАА-ны төлөвлөгөө, үнэлсэн байдал
10. Захиалагч болон үнэлгээний хорооны үйл ажиллагаа
11. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, түүний чанар, чанарт өгсөн үнэлгээ
12. 2019 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдаж дутуу хэрэгжсэн төсөл, арга хэмжээний судалгаа
13. Захиалагч ба гүйцэтгэгчийн үүрэг, хариуцлага
14. Санхүүжилт, гэрээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналт
15. Хөрөнгө оруулалтын төсвийн зарцуулалтын хяналт
16. Нийгмийн салбарын нийгэм, эдийн засгийн үр ашиг
17. Хөрөнгө оруулалтын санхүүжилт
18. Аудитын зөвлөмж



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Хаяг: Дорнод аймаг, Хэрлэн сумын VII баг, аймгийн ЗДТГ-ын 2-р байр, 1, 2 давхарт

Утас: 7058-4203, 7058-4204

Цахим шуудан: [dornod@audit.gov.mn](mailto:dornod@audit.gov.mn)

<http://audit.mn/>



# “МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ




Улсын төсвөөс 2019 онд Дорнод аймагт эрх шилжиж хэрэгжсэн төсөл, арга хэмжээний тоо 3.4 дахин, санхүүжих дүн 8.1 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

### УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО




Шинээр сургууль, цэцэрлэг барих, засварлах зэрэг нийгмийн салбарын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд түлхүү чиглэгдсэн.

### ЭРХ ШИЛЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ



МУ-ын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт хугацаанд хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий төсөл, арга хэмжээ хамаардаг учраас Дорнод аймагт 2019 онд хэрэгжих төсөл, арга хэмжээнүүд уг хөтөлбөрт тусгагдаагүй байна.

### ДОРНОД, УЛСЫН ТӨСВӨӨС ЭРХ ШИЛЖСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САЛБАРААР





# “МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮН



Аудитад Монгол Улсын 2019 оны төсөвт батлагдсан 18 төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг хамруулав.

### ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ

Тоо: 16



Мөнгөн дүн:  
**9.6**  
тэрбум төгрөг



### ГОЛ ЗӨРЧИЛ



ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГАА

ТӨСӨЛ, АРГА  
ХЭМЖЭЭНИЙ  
ГҮЙЦЭТГЭЛ

- Шинээр эхлүүлэх зураг төсөв шаардагдах **6.6** тэрбум төгрөгийн **6** төсөл, арга хэмжээний зураг төсөв улсын төсөв батлагдсанаас хойш баталгаажсан.
- Зураг, төсөв хэрэглэгчийн шаардлагад бүрэн нийцээгүй.

Холбогдох Яамдаас төсөл, арга хэмжээний **94** хувийг хугацаа хоцроож эрх шилжүүлсэн.

Зураг хийгдээгүй, ажлын даалгавар дутуу ажилд ХАА-г зохион байгуулсан.

- Хугацаандаа хэрэгжээгүй: **2** төсөл, арга хэмжээ
- Он дамжих: **6** төсөл, арга хэмжээ



## УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2019 ОНД АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

Төрийн үйлчилгээний 1 барилга /Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн хөгжлийн төв/

270 ортой 2 цэцэрлэг /Хэрлэн сумын 17, 18-р цэцэрлэг/

9 сургууль, цэцэрлэгийн барилга, спорт заал, сантехник, цахилгааны их засвар /Хэрлэн, Дашбалбар, Баяндун, Чойбалсан, Матад/

1 ЭМТ-ийн моргийн барилга /Цагаан-Овоо сум/

1 ЭМТ-ийн барилгын их засвар /Цагаан-Овоо сум/

АО503 кодтой Чойбалсан-Сүмбэр-Нөмрөг чиглэлийн авто замын эхлэл дэх Хэрлэн голын доод төмөр бетон гүүрийн их засвар, шинэчлэлт, 264 у/м /Дорнод, Хэрлэн сум/



# “МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд нь Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2019 онд нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцэж байна.

### Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр



МУ-ын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт хугацаанд хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий төсөл, арга хэмжээ хамаардаг учраас Дорнод аймагт 2019 онд хэрэгжих төсөл, арга хэмжээнүүд уг хөтөлбөрт тусгагдаагүй байна.

## ЗАХИАЛАГЧИЙН САНАЛД ҮНДЭСЛЭСЭН БАЙДАЛ

Орон нутагт эрх шилжиж ирсэн 18 төсөл, арга хэмжээнээс 14 төсөл, арга хэмжээний саналыг холбогдох төсөвт байгууллагуудаас ирүүлсэн саналын дагуу аймгийн ТЕЗ-аас улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар санал хүргүүлсэн байна. Харин 4 төсөл, арга хэмжээний санал нь ашиглагч байгууллагаас УИХ-ын гишүүнд хүргүүлсэн саналаар улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байна. Үүнд:

- Улз голын урсцыг нэмээгдүүлэх “Онон-Улз” төсөл /Онон-Улз голын сав газрын захиргаанаас санал хүргүүлсэн/
- Зүүн бүсийн ахмад настны асрамж үйлчилгээний төвийн барилгын шугам сүлжээ /Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас санал хүргүүлсэн/
- Матад сумын цэцэрлэгийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ, тохижилт их засварын ажил /Матад сумын ЗДТГ-аас санал хүргүүлсэн/
- Дорнод их сургуулийн шинэ хотхоны зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл /Дорнод их сургуулиас санал хүргүүлсэн/



# “МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ ШИНЭЭР ЭХЛЭХ БОЛОН ШИЛЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ

2019 ОНД ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР САНХҮҮЖҮҮЛЭХ

**21**  
төсөл, арга хэмжээ

**62.6%** Шинээр хэрэгжих Төслийн тоо: **18**  
Төсөвт өртөг: **11.4** тэрбум төгрөг

**37.4%** Шилжих Төслийн тоо: **3**  
Төсөвт өртөг: **6.8** тэрбум төгрөг

### УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ ТӨСЛИЙН ТОО



Өмнөх онтой харьцуулахад шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ 0.8 дахин, шилжих төсөл, арга хэмжээ 3 дахин нэмэгдсэн байна.

### 2019 ОНД ӨМНӨХ ОНООС ШИЛЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНҮҮДЭЭС

Төсөл, арга хэмжээ		Төсвийн ерөнхийлөн захирагч	Хэрэгжиж эхэлсэн он	Төсөвт өртөг (тэрбум төгрөг)
	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн хөгжлийн төвийн барилга	ХНХС	2018	4.0
	Цэцэрлэгийн барилга, 120 ор /Дорнод, Хэрлэн сум, 1-р баг/	БСШУСС	2018	1.5
	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Хэрлэн сум, 6-р баг/	БСШУСС	2018	1.3



# “МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ ТӨСЛҮҮД ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГАСАН ЭСЭХ ТАЛААРХ ДҮГНЭЛТ



**35.2%**

2019 онд шинээр эхлүүлэх зураг төсөв шаардлагатай **17** ТАХ байгаагаас нийт 6 ТАХ-ний **/35.2 хувь/** зураг, төсөв нь улсын төсөв батлагдсанаас хойш баталгаажиж, хуулийн шаардлага хангаагүй байжээ.



**64.8%**

Хуульд тусгахдаа зураг, төсвийг нь батлуулсан 11 төсөл, арга хэмжээ





**35.2%**

Хууль баталсны дараа зураг, төсвийг батлуулсан 6 төсөл, арга хэмжээ



Барилга, байгууламжийн зураг, төсвийг захиалагч болон хэрэглэгчийн шаардлагад нийцүүлээгүй тухайн ажлууд хуульд заасан хугацаандаа дуусахгүй, зорилтот үр дүндээ хүрэхгүй байх үр дагаврыг үүсгэж байгаа бөгөөд захиалагч зураг, төсвийн ажлын даалгаврыг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн боловсруулж, төсвийг бүрэн батлуулах шаардлагатай байна.

Магадлал хийлгэх шаардлагатай 5 төсөл арга хэмжээний зураг төсөвт Барилгын тухай хуулийн 25 дугаар заалтын дагуу магадлал хийлгэж баталгаажуулсан ч Баяндун сумын сургуулийн дотуур байрны барилгын ажлаас бусад 4 ажлын зураг төсөвт 2019 оны төсвийн тухай хууль батлагдсанаас хойш магадлал хийгдсэн байна. Магадлалаар 2 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг өөрчлөгдсөн байна. Үүнд:

Төсөл, арга хэмжээний нэр	Байршил	Төсвийн ерөнхийлөн захирагч	Нэмэгдсэн төсөвт өртөг (сая төгрөг)
 Цэцэрлэгийн шинэ барилга	Дорнод, Баянтүмэн сум	БСШУСС	560.0
 Соёлын төвийн барилга	Дорнод, Баян-Уул сум		362.0





# “МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Шинээр хэрэгжих 18 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга

**100%** Нээлттэй тендер шалгаруулалт

**0%** Харьцуулалт

**0%** Шууд гэрээ байгуулах

**0%** Хязгаарлагдмал тендер шалгаруулалт



### ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМИЙН АШИГЛАЛТ



**100%**

Засгийн газраас 2019 оны худалдан авах ажиллагааг бүрэн хэмжээнд цахим систем ашиглан зохион байгуулахыг даалгаж, хэрэгжилт 100 хувьтай байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАХ-НИЙ 94.0 ХУВИЙГ ХУГАЦАА ХОЦРООЖ ЭРХ ШИЛЖҮҮЛСЭН БАЙНА.



Журмын 2.11-д заасны дагуу 2019 оны төсвийн тухай хууль батлагдсан 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс хойших хугацаагаар тооцон үзэхэд, эрхийг 2019 оны 01 сарын 02-ны өдөр хүртэл буюу 60 хоногийн дотор шилжүүлэхээр байсан байна.

Үүнээс Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад хамаарах 1 төсөл, арга хэмжээний эрхийг 2018 оны 12 сарын 26-ны өдөр буюу хугацаанд нь эрх шилжүүлж, бусад 17 ажлыг 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс 02 дугаар сарын 14-нийг хүртэл 8-42 хоногоор хугацаа хоцроож шилжүүлсэн байна.

ТЕНДЕРИЙГ ЗАРЛАХДАА ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗААСАН ХУГАЦААГ МӨРДӨЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

Тендерийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан хугацаанаас 71-225 хоногоор оройтож зарласан 7 төсөл, арга хэмжээ байна.

№	Төсөл арга хэмжээний нэр	Тендер зарлах огноо	Тендер зарласан огноо	Хэтэрсэн хоног
1	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Баянтүмэн/	2019.02.11	2019.07.19	158
2	Сургуулийн барилгын их засвар /Дорнод, Дашбалбар сум/	2019.02.11	2019.05.17	95
3	Сургуулийн барилгын их засвар /Дорнод, Чойбалсан сум/	2019.02.11	2019.04.23	71
4	Дорнод их сургуулийн шинэ хотхоны зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл /Дорнод, Хэрлэн сум/	2019.02.11	2019.06.14	123
5	Соёлын төвийн барилга, 250 ор /Дорнод, Баян-Уул сум/	2019.02.11	2019.08.02	172
6	Соёлын төвийн барилгын их засвар /Дорнод, Цагаан-Овоо сум/	2019.02.11	2019.05.02	80
7	Улз голын урсцыг нэмэгдүүлэх "Онон-Улз" төсөл /Дорнод, Хэрлэн сум/	2019.03.05	2019.10.16	225





# МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ЗУРАГ ХИЙГДЭЭГҮЙ, АЖЛЫН ДААЛГАВАР ДУТУУ АЖЛУУДАД ХАА-Г ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.



Тендерийн жишиг баримт бичгийг баримтлан боловсруулсан боловч ажлын зураг, ажлын даалгавар бүрэн хийгдээгүй, зураг, төсөв зөрүүтэй ажлуудад худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Тухайлбал:

- “Хэрлэн сумын 5-р цэцэрлэгийн барилгын их засвар”-ын ажлын төсөв хийгдсэн боловч, ажлын зураг байхгүйгээс тендер шалгарсны дараа мэргэжлийн байгууллагаас үүрэг даалгавар өгсний дагуу ажлыг түр зогсоож, зураг хийлгэсний дараа гүйцэтгүүлсэн байна.
- “Баян-Уул сумын соёлын төвийн барилга”-ын ажлын зураг, төсөв зөрүүтэй буюу зурагт байсан зарим ажил төсөвт багтаагүй, хасагдаж батлагдсан байна.
- “Баянтүмэн сумын цэцэрлэгийн барилга”-ын ажилд 560.0 сая төгрөгийн дутуу төсвөөр худалдан авах ажиллагааг зарласан.
- “Цагаан-Овоо сумын соёлын төвийн барилгын их засвар”-ын ажлын зурагт хэрэглэгчээс саналыг аваагүй, зураг нь 2016 онд хийгдэж, тайзны шал, хаяавч нь батлагдсан зурагт тусгагдаагүй байна.
- “Чойбалсан сумын сургуулийн барилгын их засвар”, “Дашбалбар сумын сургуулийн барилгын их засвар”-ын ажлуудад ажлын даалгаврын тоо хэмжээ дутуу, тухайн барилгын бодит байдлыг үнэлэлгүй худалдан авах ажиллагааг зарласан.

## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОГСДЫН ӨРСӨЛДӨХ БОЛОМЖИЙГ БОДИТОЙ ҮНЭЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ БАЙНА.

2019 онд улс, орон нутгийн төсвөөс 3-аас дээш тендер авсан ААН-үүд

№	Аж ахуйн нэгжийн нэр	Улсын төсөв /ТАХ-ын тоо/	Гэрээний дүн	Орон нутгийн төсөв, ОНХС /ТАХ-ны тоо/	Гэрээний дүн	НИЙТ ТАХ тоо	НИЙТ төсөв /сая.төг/
1	“Бүжнар” ХХК	2	399.8	2	168.0	4	561.8
2	“Донж өргөө” ХХК	3	651.8	1	48.9	4	700.7
3	“Ган октаэдр” ХХК	2	159.6	3	652.5	5	812.1
4	“Талын сүлд” ХХК	2	1667.3	2	120.0	4	1787.3
5	“Дорнод хийц” ХХК	1	102.1	2	227.9	3	330.0
6	“Зэт Ай И Ти” ХХК	1	72.1	2	121.9	3	194.0
7	“Элтрүүд” ХХК	1	40.4	8	302.4	9	342.8

“Ган октаэдр” ХХК, “Талын сүлд” ХХК, “Элтрүүд” ХХК, “Зэт Ай И Ти” ХХК “Дорнод хийц”, “Донж өргөө” ХХК-ийн гүйцэтгэсэн ажлын чанарт асуудал гараагүй бөгөөд “Дорнод хийц” ХХК, “Донж өргөө” ХХК, “Зэт Ай И Ти” ХХК, “Элтрүүд” ХХК-иудын гүйцэтгэсэн 1 ажил тус бүр 2-21 хоног хугацаа хоцорсон, “Бүжнар” ХХК-ийн улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн 2 төсөл, арга хэмжээ нь чанаргүй хийгдсэн байдалтай байна.

“Бүжнар” ХХК-ийн улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн 2 төсөл, арга хэмжээ нь чанаргүй хийгдсэн нь ажиллах хүчин, техник, тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангалтгүй байсантай холбоотой байна.



# “МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## ЗАХИАЛАГЧ БОЛОН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Үнэлгээний хороог хугацаа хоцорч байгуулсан төсөл, арга хэмжээ

# 15

Хугацаа хоцорсон дундаж хоног

# 33

### ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО БАЙГУУЛСАН ХУГАЦАА (хоног, төслийн тоо)

№	Захиалагч	Нийт ТАХ-ний тоо	Хэтэрсэн ТАХ-ний тоо	Хэтэрсэн дундаж хоног
1	ХНХЯ	1	0	0
2	БОАЖЯ	1	0	0
3	ШС	1	0	0
4	ЗТХЯ	1	1	38
5	ЭМЯ	3	3	6
6	БСШУСЯ	11	11	38
7	НИЙТ	18	15	33.2



### Тендерт оролцогч иргэн, аж ахуйн нэгжүүдээс 2019 онд гаргасан гомдлын тоо

- 1 Сангийн яаманд
- 0 Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт
- 0 Шүүх байгууллагад



### Сангийн яам иргэд, аж ахуйн нэгжүүдээс ирсэн гомдлыг шийдвэрлэсэн байдал

- 100 % Тендерийн үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийх
- 0 % Гомдол үндэслэлгүй
- 0 % Тендерийг хүчингүй болгох



# “МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ



2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэл (дунджаар)

**81.0%**

### ГҮЙЦЭТГЭЛ (төсвийн ерөнхийлөн захирагчдаар)

Төсөл, арга хэмжээ

Гүйцэтгэлийн хувь

1. Стандарт, хэмжил зүйн хэлтсийн барилга /Дорнод, Хэрлэн сум/	52
2. Улз голын урсцыг нэмэгдүүлэх "Онон-Улз" төсөл /Дорнод, Хэрлэн сум/	100
3. Зүүн бүсийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн барилгын шугам сүлжээ /Дорнод, Хэрлэн сум/	100
4. Дотуур байрын барилга, 100 ор /Дорнод, Баяндун сум/	42.3
5. Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Баянгүмэн сум/	36.4
6. Сургуулийн барилгын их засвар /Дорнод, Дашбалбар сум/	100
7. Сургуулийн барилгын их засвар /Дорнод, Хэрлэн сум, 8 дугаар сургууль/	100
8. Сургуулийн барилгын их засвар /Дорнод, Чойбалсан сум/	100
9. Цэцэрлэгийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ, тохижилт их засвар /Дорнод, Матад сум/	100
10. Цэцэрлэгийн барилгын их засвар /Дорнод, Хэрлэн сум, 1, 5, 8, 14 дүгээр цэцэрлэг/	100
11. Дорнод их сургуулийн шинэ хотхоны зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл /Дорнод, Хэрлэн сум/	72.5
12. Соёлын төвийн барилга, 250 суудал /Дорнод, Баян-Уул сум/	25
13. Соёлын төвийн барилгын их засвар /Дорнод, Цагаан-Овоо сум/	31
14. Спорт заалын их засвар /Дорнод, Баяндун сум/	100
15. АО503 кодтой Чойбалсан-Сүмбэр-Нөмрөг чиглэлийн авто замын эхлэл дэх Хэрлэн голын доод төмөр бетон гүүрийн их засвар, шинэчлэлт, 264 у/м /Дорнод, Хэрлэн сум/	100
16. Эрүүл мэндийн төвийн моргийн барилга /Дорнод, Цагаан-овоо сум/	100
17. Эрүүл мэндийн төвийн барилгын засвар, гадна тохижилт /Дорнод, Цагаан-овоо сум/	100
18. Суурин рентген аппарат /Дорнод, Хэрлэн сум/	100
<b>НИЙТ</b>	<b>81.0</b>



Улсын төсвийн 18 ТАХ-нээс 6 ТАХ-ний гүйцэтгэл 25-72.5 хувьтай байгаа бөгөөд 2020 онд хэрэгжүүлэхээр шилжүүлсэн байна.



# “МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## ГЭРЭЭНИЙ ХУГАЦААНААС ХЭТЭРСЭН, ЧАНАРГҮЙ ХИЙГДСЭН АЖЛУУД БАЙНА.

Дорнод аймагт улсын төсвөөс эрх нь шилжсэн ажлуудаас 2019 онд хэрэгжиж дуусах 12, он дамжин гүйцэтгэгдэх 6 төсөл, арга хэмжээ байна. Бүрэн хэрэгжсэн ажлуудаас хугацаа хоцорч гүйцэтгэсэн 3 төсөл, арга хэмжээ байна.



### ГЭРЭЭНЭЭС ХЭТЭРСЭН ХОНОГ, ААН

ТАХ-НИЙ НЭР	ХЭТЭРСЭН ХОНОГ	ТӨСӨВТ ӨРТӨГ
Чойбалсан, Дашбалбар сумын сургуулийн барилгын их засвар, Хэрлэн сумын 1, 5, 8, 14-р цэцэрлэгийн барилгын их засвар	36	1046.6 сая төгрөг

### ГЭРЭЭНИЙ ХУГАЦААНААС ХЭТЭРСЭН ШАЛТГААН



50.0%	Цаг агаарын нөхцөл, ажлын даалгаврыг бодитой боловсруулаагүй.
38.8%	ААН давхар ажил гүйцэтгэсэн.
11.2%	Тендер оройтож зарлагдсан

### ГҮЙЦЭТГЭЛ ДУТУУ, ЧАНАРГҮЙ ХИЙГДСЭН АЖЛУУД



Дашбалбар, Баяндун сумын сургуулийн спорт заалны засвар, Чойбалсан сумын сургуулийн дотор засал, спорт заалны засварын ажлын гүйцэтгэл дутуу, чанаргүй хийгдсэн байна.



Эдгээр ажил дахь ашиглагч байгууллагын сэтгэл ханамж 40-70 хувьтай байгаа бөгөөд ажлын чанарт төлөвлөлтийн алдаа болон гүйцэтгэгч компанийн хариуцлага аль аль нь нөлөөлсөн байна.



# “МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## 2019 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ТУСГАГДАЖ ДУТУУ ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ СУДАЛГАА

2019 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 18 төсөл, арга хэмжээний 8.7 хувь нь дутуу хэрэгжсэн.



### ДУТУУ ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

НИЙТ 2 ТӨСӨЛ, АРГА  
ХЭМЖЭЭ

НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ  
1500.0 сая төгрөг

САНХҮҮЖИХ ДҮН  
1003.1 сая төгрөг



### ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ДУТУУ ХЭРЭГЖСЭН ШАЛТГААН

**50.0%** Гэрээ байгуулсан хугацаанд хэрэгжих боломжгүй болсон.

**25.0%** Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас шалтгаалсан.

**25.0%** Захиалагчийн үйл ажиллагаанаас шалтгаалж, зураг, төсөв, ТЭЗҮ дахин хийгдсэн.

### 2019 ОНД ДУТУУ ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

(сая төгрөг)

Төсөл арга, хэмжээ	Санхүүжих дүн	Эзлэх хувь	Санхүүжсэн
Улз голын урсцыг нэмэгдүүлэх "Онон-Улз" төсөл /Дорнод, Хэрлэн сум/	1,100.0	20.0	221.0
Дорнод их сургуулийн шинэ хотхоны зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл /Дорнод, Хэрлэн сум/	400.0	68.8	275.5
<b>НИЙТ ДҮН</b>	<b>1500.0</b>	<b>33.1</b>	<b>496.5</b>



2019 онд дутуу хэрэгжсэн төсөл, арга хэмжээний 31.2-80.0 хувь нь дутуу хэрэгжсэн байна.





# “МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## ЗАХИАЛАГЧ БА ГҮЙЦЭТГЭГЧИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

### АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛҮҮД:

Захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг бүрэн арилгаагүй дараах ажлууд байна. Үүнд:

№	Төсөл арга хэмжээний нэр	Гүйцэтгэсэн компани	Өгсөн үүрэг даалгавар	Тайлбар
1	Сургуулийн барилгын их засвар /Дорнод, Дашбалбар сум/ 496.6 сая төгрөг	“ЦОДММ” ХХК	Норсон хананы засварыг 2020 оны хавар дахин засварлах.	Үүрэг даалгаврын хэрэгжилтийн үлдсэн хэсгийг 2020 оны 06-р сард багтаан гүйцэтгэнэ.
2	Спорт заалны их засвар /Дорнод, Баяндун сум/ 110.1 сая төгрөг	“Бүжнар” ХХК	Ханын хуурсан хэсгийг засаж, дахин будах Шалыг харуулдах, давхарлаж будах	Үүрэг даалгаврыг 2020 оны 08 дугаар сард багтаан гүйцэтгэнэ.
3	Сургуулийн барилгын их засвар /Дорнод, Чойбалсан сум/ 300.0 сая төгрөг	“Бүжнар” ХХК	Шалыг дахин шахах, норсон хэсгийг засварлаж, дахин будах	Үүрэг даалгаврыг 2020 оны 08 дугаар сард багтаан гүйцэтгэнэ.



Эдгээр ажлуудыг тайлант онд цаг хугацааны хувьд бүрэн дуусгах боломжгүй тул, санхүүжилт татуулахгүй байх зорилгоор, хугацаатай үүрэг, даалгавар өгч ажлыг хүлээн авдаг жишиг тогтсон байна.

### ГҮЙЦЭТГЭГЧИД НЬ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.



Орон нутагт эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр шалгарсан нийт 17 аж ахуйн нэгжээс орон нутагт үйл ажиллагаа явуулдаг 10 аж ахуйн нэгж байна. Аудитын явцад орон нутгийн 7 аж ахуйн нэгжийг түүвэрт хамруулан шалгахад “Бүжнар” ХХК, “Дорнод хийц” ХХК, “Талын сүлд” ХХК, “Донж өргөө” ХХК, ЦОДММ ХХК-ууд шаардлагатай баримтуудыг ирүүлж, Дөшийн нуруу ХХК, Дорнын оч ХХК-иуд коронавирус өвчинтэй холбоотойгоор хотод байгаа, мөн хувийн шалтгааны улмаас баримт материалаа ирүүлээгүй. Баримт, материалыг ирүүлсэн гүйцэтгэгчид нь санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

### ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.



Төсвөөс захиалагчийн хяналтын зардалд 110,7 сая төгрөг, зохиогчийн хяналтын зардалд 22.4 сая төгрөгийг зарцуулсан байна. Зохиогчийн хяналтын зардлыг зураг, төсөв зохиогч хувь хүн, аж ахуйн нэгжид олгосон бол захиалагчийн хяналтын зардлыг ГХБХБ-ын газарт олгосныг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дансанд бүрэн төвлөрүүлж ажилласан байна.

Тус газраас хэрэгжүүлсэн захиалагчийн хяналтын ажлын үр дүнг хангалттай гэж үнэлсэн бөгөөд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд гарч байгаа зөрчил дутагдал нь захиалагчийн хяналтаас шалтгаалаагүй байна.



# “МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ХЯНАЛТ

Он дамжин гүйцэтгэгдэж байгаа төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү олгосон байна.

### ТЕЗ-ИЙН ХЯНАЛТ



САНГИЙН ЯАМ

Эрх шилжсэн төсөл, арга хэмжээний хувьд санхүүжилтийг олгохдоо журмыг мөрдөж ажилласан эсэхийг үзэхэд Баяндун сумын дотуур байрны ажлын гүйцэтгэл 2019 оны эцэст 30.0 хувьтай байхад 42.3 хувийн санхүүжилт олгосон нь гүйцэтгэлд ногдох дүнгээс 145.5 сая төгрөгөөр илүү байна.

Цагаан-Овоо сумын соёлын төвийн ажлын гүйцэтгэл одоогийн байдлаар 80.0 хувьтай байхад санхүүжилт 40.0 хувьтай олгогдсон байгаа нь ажлын үр дүнд нөлөөлж болзошгүй байгааг анхаарах шаардлагатай байна.

## ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН ДОТООД ХЯНАЛТ ХИЙГДЭЭГҮЙ БАЙНА.



Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2019 оны аймагт эрх нь шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдэд хяналт шалгалтыг 2020 оны 11 дүгээр сард хийхээр төлөвлөгөөнд оруулж ТЕЗ-аар батлуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.”

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.2.4-т “төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих”, 8.5-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ”



Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас аймгийн ТЕЗ-ийн 2018 оны санхүүгийн үйл ажиллагаа, 2019 оны санхүүгийн үйл ажиллагааны явцад хяналт шалгалтыг хамтарсан байдлаар хийсэн байна.

Уг шалгалтаар улсын төсвийн эрх шилжсэн 2018 оны хөрөнгө оруулалтын ажил, мөн олон жил дамжсан, дуусаагүй 4 барилгын ажлын явцыг хамруулсан байна.





# “МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## НИЙГМИЙН САЛБАРЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШИГ

Хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцоогүй, зорилтот үр дүндээ хүрээгүй төсөл, арга хэмжээ байна.



- Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.11-д “УТХО-ын нийгэм, эдийн засагт үзүүлэх үр ашиг, үр дүнг тооцох аргачлал”-ыг Засгийн газрын гишүүн, хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална” гэж заасны дагуу Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 295 дугаар тогтоолоор уг аргачлал батлагдсан нь баталж 2020 оноос мөрдөж эхлэхээр заасан байна.
- Улсын төсвөөс Дорнод аймагт эрх шилжиж ирсэн 18 төсөл, арга хэмжээг төсөвт тусгуулах санал хүргүүлэхдээ, тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээс бий болох үр дүнгийн талаар тооцоо судалгаа хийгээгүй байна.

**ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТААС  
БИЙ БОЛОХ  
ҮР АШГИЙГ  
ТООЦООГҮЙ.**



Тухайн жилд төлөвлөсөн гүйцэтгэлээс 1003.1 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэгдсэн 2 төсөл арга хэмжээ байна. Төлөвлөсөн зорилтот түвшин бүрэн хангагдаагүй, чанаргүй хийгдсэн 3 ТАХ-ний ажлууд байна. Үүнд:



- *Сургуулийн барилгын их засвар /Чойбалсан сум/- Спорт заалны шал муу хийгдсэнээр хүүхдүүд хичээллэхэд сөрөг нөлөө үзүүлдэг. Ашиглагч талаас сэтгэл ханамж дунд, хангалтгүй хийгдсэн гэсэн үнэлгээ өгсөн.*
- *Спорт заалны их засвар /Баяндун сум/-Шалны тэгшилгээ, будаг дутуу хийгдсэн нь будаг ховхорч харагдах байдал талаас муу, ашиглагч талаас сэтгэл ханамж дунд, хангалтгүй хийгдсэн гэсэн үнэлгээ өгсөн.*
- *Сургуулийн барилгын их засвар /Дашбалбар сум/- Спорт заалны шал ховхорсон, дулаан алдалт өмнөх жилүүдээс нэмэгдээгүй, ашиглагч талаас сэтгэл ханамж дунд, хангалтгүй хийгдсэн гэсэн үнэлгээ өгсөн.*



Цаашид “УТХО-ын нийгэм, эдийн засагт үзүүлэх үр ашиг, үр дүнг тооцох аргачлал”-ыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.



# “МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНХҮҮЖИЛТ

САНХҮҮЖИЛТИЙГ ОЛГОХДОО СС-ЫН 2016 ОНЫ 415 ДУГААР ТУШААЛААР БАТАЛСАН ЖУРМЫГ БҮРЭН МӨРДӨЖАЖИЛЛААГҮЙ БАЙНА.



Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгож байгаа хэдий ч худалдан авах ажиллагааны үр дүнгийн биелэлтийг мэдээллийг гүйцэтгэл, санхүүжилтийн баримтад хавсаргаж, баримтжуулаагүй, 4 төсөл, арга хэмжээнд гүйцэтгэлийн баталгаа батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.5.3, 4.5.5 дахь заалтад нийцэхгүй байна.

## УРДЧИЛГАА ТӨЛБӨРИЙН БАТАЛГАА БОЛОН БАРЬЦАА ХӨРӨНГИЙН ДАНСАНД БАЙРШУУЛСАН ЭСЭХ

**79.9%**

Улз голын урсцыг нэмэгдүүлэх "Онон-Улз" төсөл /Дорнод, Хэрлэн сум/-Хэрэгжиж дуусаагүй, батлагдсан төсөв 2019 онд 1100.0 сая төгрөг, гүйцэтгэл 221.0 сая төгрөг, 879.0 сая төгрөг буюу нийт санхүүжилтийн 79.9 хувийг барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлж авсан байна.

**27.5%**

Дорнод их сургуулийн шинэ хотхоны зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл /Дорнод, Хэрлэн сум/- Зураг төсөв, ТЭЗҮ-н материалыг хүлээж аваагүй байна. Батлагдсан төсөв 2019 онд 380.0 сая төгрөг, гүйцэтгэл 275.5 сая төгрөг, урьдчилгаа төлбөрийн баталгаагаар 104.5 сая төгрөг буюу нийт санхүүжилтийн 27.5 хувийг авсан байна.

**30.0%**

Соёлын төвийн барилга, 250 суудал /Дорнод, Баян-Уул сум/-Хэрэгжиж дуусаагүй, 2019 онд 455.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан. Үүнээс гүйцэтгэлээр 312.3 сая төгрөг, урьдчилгаа төлбөрийн баталгаагаар 136.7 сая төгрөг буюу нийт санхүүжилтийн 30.0 хувийг авсан байна.



# “МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ НЬ

- Хөрөнгө оруулалтын дутуу хийгдсэн ажлыг шинж чанараас нь хамааран дараа онд шилжүүлж, үлдсэн санхүүжилтийг орон нутгийн төсөвт үлдээх асуудлыг эрх зүйн зохицуулалтаар шийдвэрлэх талаар холбогдох газарт санал хүргүүлэх.
- Орон нутагт төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлэхдээ журамд заасан хугацааг мөрдөөгүй ТЕЗ-дад тооцох хариуцлагын талаар зохицуулалт бий болгох саналыг холбогдох газарт хүргүүлэх.

### АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД

- Барилга, байгууламжийн зураг, төсвийн ажлын даалгаврыг боловсруулах ажлын үр дүнг сайжруулах.
- Төсвийн тухай хуулийн 29.4 дэх хэсэгт заасан холбогдох зөвшөөрлүүд бүрэн олгогдсон төсөл, арга хэмжээг төсөвт тусгуулах.
- Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд гарсан зөрчлүүдийг арилгаж, худалдан авах ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах.
- Хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгох.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлуудад тавих дотоод хяналтыг цаг хугацаанд нь хийж, үр ашгийг тооцон, үр дүнг үнэлэх ажлыг зохион байгуулах.